



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/03/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор П.Энхжаргал

Утас: 9974-3112

Цахим хаяг: EnkhjargalP@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	14
Тухайн байгууллага нь тайлант онд үндсэн хөрөнгийн орлого дансанд 124.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулга хийлгэлээ.	
4.1. Залруулсан алдаа	14
4.2. Төлбөрийн акт	14
4.3. Албан шаардлага	14
4.4. Зөвлөмж.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗГ	Засгийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

1. Аудитын санал дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 140
танай _____ -ны № _____ -т

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗРЫН ДАРГА Х.ГАНХУЯГ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>297,389,636.00</u>	<u>246,953,780.00</u>
33	АВЛАГА	1,456,380.00	86,619,180.00
335	Бусад авлага	1,456,380.00	86,619,180.00
3351	Байгууллагаас авах авлага	-	85,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,456,380.00	1,619,180.00
35	БАРАА МАТЕРИАЛ	295,933,256.00	160,334,600.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	295,933,256.00	159,800,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	534,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,878,663,345.22</u>	<u>25,699,344,330.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,878,663,345.22	<u>25,699,344,330.50</u>
392	Биет хөрөнгө	14,877,489,345.26	25,698,607,330.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,266,976,380.00	6,283,510,972.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52,931,073.43	-122,616,376.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	35,000,000.00	35,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-35,000,000.00	-35,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,363,694,474.26	3,394,388,987.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-494,452,610.07	-643,660,194.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,825,789.23	44,603,769.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,905,171.91	-13,198,145.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,342,877,070.46	17,393,718,938.26
39215	Хуримтлагдсан элэгдэл	-253,799,775.28	-755,963,536.96
39216	Дуусаагүй барилга, байгууламж	3,702,204,262.00	117,822,916.00
393	Биет бус хөрөнгө	1,173,999.96	736,999.92
39301	Програм хангамж	1,611,000.00	1,611,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-437,000.04	-874,000.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>15,176,052,981.22</u>	<u>25,946,298,110.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>85,537,200.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	85,537,200.00
413	Өглөг	-	537,200.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	537,200.00
414	Урьдчилж орсон орлого	-	85,000,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	85,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>15,175,678,581.22</u>	<u>25,860,760,910.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	15,175,678,581.22	25,860,760,910.50
512	Хуримтлагдсан үр дүн	15,083,420,109.26	25,768,502,438.54
51210	Өмнөх үеийн үр дүн	15,083,420,109.26	15,083,420,109.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	10,685,082,329.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	92,258,471.96	92,258,471.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>15,175,678,581.22</u>	<u>25,946,298,110.50</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,465,516,095.37	15,369,757,151.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,322,183,195.37	15,217,398,851.14
120	Нийтлэг татварын бус орлого	8,322,183,195.37	15,217,398,851.14

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,322,183,195.37	7,973,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,283,000.00	7,973,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,311,900,195.37	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		15,208,891,251.14
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		534,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,332,900.00	152,358,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	143,332,900.00	152,358,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,332,900.00	152,358,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,238,632,557.76	1,010,400,395.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,238,632,557.76	1,010,400,395.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,236,493,513.66	1,004,596,810.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,570,397.90	116,017,280.89
210101	Үндсэн цалин	109,079,754.90	107,365,281.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,490,643.00	8,651,999.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,624,100.00	15,321,327.98
210201	Тэтгэврийн даатгал	10,994,700.00	10,763,973.20
210202	Тэтгэмжийн даатгал	1,157,300.00	1,184,779.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	925,900.00	940,963.34
210204	Ажилгүйдлийн даатгал	231,500.00	221,182.95
210205	Эрүүл мэндийн даатгал	2,314,700.00	2,210,429.30
2104	Хангамж, бараа материалын зардал	9,326,300.00	11,123,498.00
210401	Бичиг хэрэг	4,922,500.00	6,275,210.00
210402	Тээвэр, шатахуун	2,026,300.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,377,500.00	2,590,777.00
210404	Ном, хэвлэл	-	257,511.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,900,000.00	990,000.00
210604	Урсгал засвар	1,900,000.00	990,000.00
2107	Томилолт, зочны зардал	996,600.00	1,266,500.00
210702	Дотоод албан томилолт	996,600.00	1,266,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,159,458.00	3,968,108.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,562,000.00	2,695,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,458.00	101,108.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	110,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	62,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,085,916,657.76	855,910,095.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,819,326,001.00	136,133,256.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	266,590,656.76	719,776,839.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,139,044.10	5,803,585.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	5,558,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,558,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	4,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,139,044.10	245,085.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,139,044.10	245,085.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-6,773,116,462.39	14,359,356,755.42
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	910,233,280.73	3,674,274,426.14
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	904,114,485.73	3,674,274,426.14
225002	Найдваргүй авлагын алдагдал	6,118,795.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-910,233,280.73	-3,674,274,426.14
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-7,683,349,743.12	10,685,082,329.28

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,258,471.96	15,083,420,109.26	15,175,678,581.22
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	92,258,471.96	15,083,420,109.26	15,175,678,581.22
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,258,471.96	15,083,420,109.26	15,175,678,581.22
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	92,258,471.96	15,083,420,109.26	15,175,678,581.22
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	92,258,471.96	15,083,420,109.26	15,175,678,581.22
D08	Тайлант үеийн үр дүн	-	10,685,082,329.28	10,685,082,329.28
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,258,471.96	25,768,502,438.54	25,860,760,910.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	153,615,900.00	160,331,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,283,000.00	7,973,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,283,000.00	7,973,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,283,000.00	7,973,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,283,000.00	7,973,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143,332,900.00	152,358,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	143,332,900.00	152,358,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,332,900.00	152,358,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	153,615,900.00	154,490,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	153,615,900.00	154,490,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,476,855.90	148,686,714.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,570,397.90	115,981,280.89
210101	Үндсэн цалин	109,079,754.90	107,329,281.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,490,643.00	8,651,999.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,624,100.00	15,321,327.98
210201	Тэтгэврийн даатгал	10,994,700.00	10,763,973.20
210202	Тэтгэмжийн даатгал	1,157,300.00	1,184,779.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	925,900.00	940,963.34
210204	Ажилгүйдлийн даатгал	231,500.00	221,182.95
210205	Эрүүл мэндийн даатгал	2,314,700.00	2,210,429.30
2104	Хангамж, бараа материалын зардал	9,326,300.00	10,954,498.00
210401	Бичиг хэрэг	4,500,000.00	5,806,721.00
210402	Тээвэр, шатахуун	2,026,300.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,649,777.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	498,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,900,000.00	990,000.00
210604	Урсгал засвар	1,900,000.00	990,000.00
2107	Томилолт, зочны зардал	996,600.00	1,266,500.00
210702	Дотоод албан томилолт	996,600.00	1,266,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,059,458.00	4,173,108.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,362,000.00	2,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,458.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	110,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	63,108.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,139,044.10	5,803,585.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	5,558,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,558,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	4,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,139,044.10	245,085.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,139,044.10	245,085.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	5,841,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	5,841,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,841,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,841,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,841,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(5,841,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	160358300.00	160086214.87	272085.13	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160358300.00	160086214.87	272085.13	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154799800.00	154527714.87	272085.13	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	116001300.00	115981280.89	20019.11	100.0
210101	Үндсэн цалин	106497300.00	107329281.59	-831981.59	100.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9504000.00	8651999.30	852000.70	91.0

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15328200.00	15321327.98	6872.02	100.0
210201	Тэтгэврийн даатгал	10768000.00	10763973.20	4026.80	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1185300.00	1184779.19	520.81	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	942300.00	940963.34	1336.66	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	222100.00	221182.95	917.05	99.6
210205	Эрүүл мэндийн даатгал	2210500.00	2210429.30	70.70	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	10954500.00	10954498.00	2.00	100.0
210401	Бичиг хэрэг	5814500.00	5806721.00	7779.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	2000000.00	2000000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,000.00	2,649,777.00	-9777.00	100.4
210404	Ном, хэвлэл	500,000.00	498,000.00	2000.00	99.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	990,000.00	10000.00	99.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	990,000.00	10000.00	99.0
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,266,500.00	233500.00	84.4
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,266,500.00	233500.00	84.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,015,800.00	10,014,108.00	1692.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,700,000.00	2,700,000.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	100,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	110,000.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	64,800.00	63,108.00	1692.00	97.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,541,000.00	6,541,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,558,500.00	5,558,500.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,558,500.00	5,558,500.00	0.00	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,558,500.00	1,558,500.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	160,358,300.00	160,086,214.87	272085.13	99.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	152,358,300.00	152,113,214.87	245085.13	99.8
132001	Орон нутгийн төсвөөс	152,358,300.00	152,113,214.87	245085.13	99.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,000,000.00	7,973,000.00	27000.00	99.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	7,973,000.00	27000.00	99.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	9	9		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8		100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналт, анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 23 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн талаар гаргасан бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, удирдлагыг сайжруулах, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авалтын ажиллагааг батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх боломжийг хангах зорилготой ажилладаг аймгийн ТЕЗ-ийн харъяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь 2021 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас баталж ирүүлсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн жишиг төслийг баримтлан ажилласан байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 160.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 2.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 10,744.9 сая төгрөгөөр буюу 70.8 хувиар өссөн бөгөөд материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Авлага	1.5	86.6	85.1	5,673.3
Бараа материал	295.9	160.3	(135.6)	(45.8)
Үндсэн хөрөнгө	14,878.6	25,674.0	10,795.4	72.6
Нийт хөрөнгө	15,176.0	25,920.9	10,744.9	70.8
Өр төлбөр	0.3	0.5	0.2	66.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	15,175.7	25,920.4	10,744.7	70.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,176.0	25,920.9	10,744.9	70.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 5 дахин өссөн байна.

Авлагын данс нь 1.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд бусад зардлын авлага 85.1 сая төгрөгөөр нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 86.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 45.8 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 295.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9.3 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 0.5 сая төгрөг нийт 9.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 9.3 сая төгрөгөөр, дуусаагүй үйлдвэрлэл данснаас Хот тохижилт үйлчилгээний газар руу шилжүүлсэн 136.1

сая төгрөгөөр нийт 145.4 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 160.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 72.6 хувиар өссөн байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 14,878.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 5.8 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 15,192.8 сая, нийт 15,198.6 сая төгрөгөөр нэмэгдэж, акталж, устгасан 1.1 сая, бусад байгууллагад шилжүүлсэн үндсэн хөрөнгө /элэгдэл хасагдсан дүнгээр/ 3,673.1 сая төгрөг, тайлант хугацаанд байгуулсан 729.0 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, нийт 4,403.2 сая төгрөгөөр хасагдаж, 25,674.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Засгийн газрын хувь оролцоо 70.8 хувиар өссөн байна.*

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 25,920.9 сая төгрөг болж 10,744.9 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн 10,744.7 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөг/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	143.3	152.3	9.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10.3	8.0	-2.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,133.7	15,269.1	6,135.4
Үйл ажиллагааны орлого	9,287.3	15,429.4	6,142.1
Бараа, ажил үйлчилгээний зардал	15,236.5	1,004.6	-14,231.9
Урсгал шилжүүлэг	2.1	5.8	3.7
Үйл ажиллагааны зардал	15,238.6	1,010.4	-14,228.2
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	910.2	3,674.3	2,764.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-6,861.5	10,744.7	17,606.2

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 9.0 сая төгрөг буюу 6.3 хувиар өссөн нь цалин өссөнтэй холбоотой байна.Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 154.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 6.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 160.4 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 160.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 160.1 сая төгрөг зарцуулж 0.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын даргаар ажиллаж байсан Х.Ганхуяг нь аймгийн Засаг даргын захирамжаар ажлаас халагдаж А.Оюун-Эрдэнэ томилогдон 6 сар ажиллаад Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 109/ШШ2021/0035 дугаартай шийдвэрийн дагуу Х.Ганхуяг нь эргэж томилогдсон байна. Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрийг байгууллагын төсвөөс төлөөгүй байна. Буруутай шийдвэр гаргасан этгээд буюу аймгийн засаг даргаар ажиллаж байсан Д.Золжаргалаар эргүүлэн төлүүлэх шийдвэр гаргасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг гаргасан хэдий ч үнэлгээ хийгдээгүй байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 160.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 160.1 сая төгрөгийг зарцуулж, 99.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

- Албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд 1.8 сая төгрөг, албан томилолтын зардалд 22.3 сая төгрөг, бусад тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Суудлын автомашин ашиглалтын хувьд: Орон нутгийн өмчийн газар нь 1 тээврийн хэрэгсэлтэй бөгөөд 35.0 сая төгрөгийн анхны өртөгтэй, шатахууны зардалд 2.0 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 1.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Бараа үйлчилгээний урсгал зардлуудаас 0.03 сая төгрөгийг хэмнэсэн нь нийт батлагдсан төсвийн 0.1 хувьтай тэнцүү байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байдаг.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2021 онд нийт 146.8 сая төгрөгийн 150 мэдээлэхээс 139 мэдээллийг хугацаанд нь ил тод мэдээлсэн хэдий ч 7 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаа хоцроон, 4 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан тул Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг хугацаанд нь шилэн дансанд мэдээлж ажиллах албан шаардлагыг хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Тус байгууллага нь батлагдсан төсвийн 0.8 хувийг хэмнэж 0.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба 9.2 хувийн буюу 2.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Тайлант онд Дархан Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүгчийн 2018.01.04-ний 34 дүгээр захирамжийн дагуу хариуцагчаас 85.0 сая төгрөгийг гаргуулж Архангай аймгийн төсөвт нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн авлага барагдаагүйгээс тухай байгууллагад авлагаар тусгагдсан байгаа нь тухайн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналттай холбоотой зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж биелэлтийг 2021 оны 5 дугаар сарын 20-ний 183 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үндсэн хөрөнгийн орлого, зарлагыг тушаал шийдвэртэй тулган шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 135.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 124.9 сая төгрөгийн алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10.2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлж, 0.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Тухайн байгууллага нь тайлант онд үндсэн хөрөнгийн орлого дансанд 124.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулга хийлгэлээ.

4.2. Төлбөрийн акт

- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дуудлага худалдаагаар худалдсан хөрөнгөөс үлдсэн төлбөртэй холбоотой 0.4 сая төгрөгийн авлагатай байгаа зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.3. Албан шаардлага

- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсөвт зохицуулалт хийлгүйгээр мэдээлэл, технологийн үйлчилгээ зардлаас үндсэн хөрөнгө худалдан авсан 5.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн тухай авах зарим арга хэмжээ”-ний 1.4 “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад.....албан конторын тавилга, тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 2.1.1, 2019 оны 74-р тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах хяналт тавих журмын 5.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар түрээсийн орлоготой холбоотой 1.2 сая төгрөгийн авлага, мөн орон сууцны түрээсийн өр төлбөрт 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй нийт 1.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.”Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д заасны дагуу батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.2-д заасны дагуу батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах

Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан томилолтын зардлыг анхан шатны баримтаар тулган шалгахад 0.2 сая төгрөгийн албан томилолтын зардал гарсны удирдамж, ажлын тайлан, илтгэх хуудас байхгүй, анхан шатны баримтын иж бүрдэл дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Иймд албан томилолтын зардлыг олгохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ОНӨГ	6	127.2	2	124.9	1	0.4	1	1.7	2	0.2
Дүн		6	127.2	2	124.9	1	0.4	1	1.7	2	0.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ОНӨГ	2	8.5	0	0	0	0	2	8.5		
Дүн		2	8.5	0	0	0	0	2	8.5		
Нийт дүн		8	135.7	2	124.9	1	0.4	3	10.2	2	0.2